



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Г

Г

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооны 2023 оны 113 тоот тогтоол, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн хүсэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус хорооноос зарласан Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурvas ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичгийн 3.7.1, 3.7.2-т заасны дагуу 76.1 МГц-ийн радио давтамжийн зурvasыг Олон нийтийн радиогийн нэгдүгээр сувгийг дамжуулах зорилгоор “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-т 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 5 жилийн хугацаатай олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ
ГИШҮҮД Ч.ЗОЛБАЯР
А.ЛУВСАН-ОЧИР
Н.МАНДАХБААТАР